

## Шинэчилсэн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын шинэ шаардлагууд

### Холбоо барих:

#### Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер  
Татвар, Хуулийн зөвлөх  
үйлчилгээ  
sergi.kobakhidze@pwc.com

#### Чойжамцын Цэндмаа

Захирал  
Татвар, Хуулийн зөвлөх  
үйлчилгээ  
tsendmaa.choijamts@pwc.com

#### Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний менежер  
Татвар, Хуулийн зөвлөх  
үйлчилгээ  
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

#### Батчулууны Амаржаргал

Хуулийн үйлчилгээний менежер  
Татвар, Хуулийн зөвлөх  
үйлчилгээ  
amarjargal.batchuluun@pwc.com

#### Өмгөөллийн

#### ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар  
603 тоот, Улаанбаатар  
14200, Монгол улс  
Утас : + 976 70009089  
[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)



### Хураангуй

Монгол Улсын Засгийн газар 2023 оны 02 сарын 08-ны өдөр Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмыг (шинэ БОНУЖ) шинэчлэн баталсан. Шинэ БОНУЖ-аар төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс гадна нийгэмд үзүүлэх нөлөөллийг илүү нарийвчилсан шалгуураар үнэлж, зохих арга хэмжээ авах шаардлагыг заажээ. Иймд томоохон төслүүдийн нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоотой шинэ шаардлагуудыг үүгээр онцолж байна.



### Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд хамаарах голлох шинэ шаардлагууд

#### Байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд тусгах нэмэлт шаардлагууд:

Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн уламжлал, ёс заншил, ахуйн нөхцөл, орлого, амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө, газар өмчлөл, эзэмшил, ашиглалт, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ, төслийн талаарх олон нийтийн төсөөлөл, хэрэгцээ, хандлага, санал, хүсэлт зэргийн талаар мэдээллийг бүрэн оруулах шаардлагатай болсон.

#### Менежментийн төлөвлөгөөнд тусгах асуудлын цар хүрээ өргөжсөн нь:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ("Менежментийн төлөвлөгөө")-ний цар хүрээг өргөжүүлсэн буюу уг төлөвлөгөөнд төслийн нийгмийн нөлөөллийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг нарийвчлан тусгах шаардлага бий болсон.

Томоохон төслүүдийн хувьд нутгийн иргэдийн амьдралын чанар, хөдөлмөр эрхлэлт, аж ахуй, орлого, хөрөнгө, эрүүл, аюулгүй байдал, эрүүл мэнд, хүний эрх, жендер, соёл уламжлал зэрэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах зөрчигдсэн эрхийг сэргээх, шилжүүлэн суурьшуулалт, нөхөн олговор, соёлын өвийг хамгаалах, олон нийтийн оролцоо, төслийн мэдээллийн ил тод байдал, гомдол барагдуулах арга хэмжээ зэргийг нарийвчлан төлөвлөгөөнд тусгахыг шаардах болсон.





## Менежментийн төлөвлөгөө боловсруулахтай холбоотой голлох өөрчлөлтүүд

### 01 Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах



Менежментийн төлөвлөгөөнд нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгайлан тусгахыг шаардсан бөгөөд үүнд нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, эрх ашиг, хөдөлмөр эрхлэлт, жендэр, амьжиргаанд төслийн үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах буюу эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн заахыг шаардсан. Ингэхдээ, авч хэрэгжүүлэх арга хэмжээ бүрийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хариуцах байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах төсвийг тодорхой заах шаардлагатай.

### 02 Олон нийтийн хэлэлцүүлгийн төлөвлөгөө боловсруулах

Төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцад оролцогч талуудын оролцоог хангах буюу зөвлөлдөх уулзалтын төлөвлөгөөг талуудын оролцоотой хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан боловсруулсан байхыг шаардана.



### 03 Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговортой холбоотой төлөвлөгөө боловсруулах



Өмнөх журмаар нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх төлөвлөлт, иргэдийн эрүүл мэнд, эрх ашиг дахь төслийн нөлөөлөл гэсэн ерөнхий асуудлыг Менежментийн төлөвлөгөөнд тусгахыг шаарддаг байсан. Харин шинэ журамд илүү нарийвчилсан буюу нөлөөллийн бүсэд хамрагдаж байгаа иргэдийг тодорхойлж, нүүлгэн шилжүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд нөхөн олговор олгох нөлөөлөл үүсэх эсэхийг хянан магадлахаас гадна, нөхөн олговор олгогдож, шилжүүлэн суурьшсан өрх, иргэний нөхцөл байдлын үнэлгээг төслийн дунд болон дуусах үе шатанд мөн хийж байх, энэ талаарх гомдол хүлээн авч, барагдуулах талаар авах арга хэмжээг Менежментийн төлөвлөгөөнд заавал тусгахыг заасан байна.

### 04 Гомдол барагдуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэлт зэрэг төслийн нөлөөлөлтэй холбоотой олон нийтийн гомдлыг хүлээн авч, шалган шийдвэрлэх механизмтэй байх шаардлагатай бөгөөд энэ талаар авах арга хэмжээг Менежментийн төлөвлөгөөнд тусгах шаардлагатай болсон.



### 05 Соёлын өвийг хамгаалахтай холбоотой төлөвлөгөө боловсруулах



Соёлын өвийг хамгаалах талаарх шаардлагыг шинэ журмаар илүү нарийвчилсан. Түүх болон соёлын өв, дурсгалт газрууд нь төслийн нөлөөлөлд өртөх эрсдэлтэй нь тогтоогдвол соёлын өвийг хамгаалах, мөн төслийн үйл ажиллагааны үед санамсаргүй олдвор олдох үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох журмын дагуу боловсруулсан байх шаардлагатай. Цаашлаад төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх арга хэмжээг нарийн зааж Менежментийн төлөвлөгөөнд тусгасан байна.



## Бусад онцлох нэмэлт өөрчлөлтүүд



### Дотоод хяналт тавих ажлын хэсэг байгуулах

Хуучин журмаар төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий оролцогч талуудын төлөөллийг оролцуулсан хамтарсан ажлын хэсгийг байгуулах боломжтой байхаар заасан байсан бол шинэ журмаар төсөл хэрэгжүүлэгчид нь уг ажлын хэсгийг зайлшгүй байгуулах шаардлагатай болсон байна.



### Тайлагнах хугацаанд орсон өөрчлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамтаар харъяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 11 сарын 01-ний дотор хүргүүлэхээр заажээ.



## Цаашид төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээ



Бизнесийн үйл ажиллагааны нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь хүний эрхийн зөрчил байдлаар илэрдэг. Иймд бизнес эрхлэгчид өөрийн үйл ажиллагаанаас хамааралтай нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөө бууруулах, арилгах мөн түүнээс урьдчилан сэргийлэх, нэгэнт хүний эрхийг зөрчсөн бол эрхийг нь сэргээн эдлүүлэх арга хэмжээг авах талаар дотоод бүтэц, үр дүнтэй хяналтын системтэй байх шаардлага улам бүр бий болж байна. Энэ талаар дэлхийн олон улс хуулийн шаардлагаа нарийвчлан тогтоож, бизнесийн байгууллагаас хүний эрхийн магадлан шинжилгээг тогтмол хийдэг байх шаардлага тавих болсон.

Манай улсын хувьд Засгийн газар 2023 оны 231-р тогтоолоор “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)”-г (“Үндэсний Төлөвлөгөө”) баталсан бөгөөд уг төлөвлөгөөний 11-д “иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, өндөр эрсдэлтэй салбарт төсөл хэрэгжүүлэхэд хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг арилгах, газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх” хэмээн заасан байдаг. БОНУЖ-ыг шинэчлэн баталсан явдал нь Үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас авч буй арга хэмжээнүүдийн нэг гэж бид харж байна. Цаашдаа ч мөн Үндэсний төлөвлөгөөнд заасанчлан хувийн хэвшлийн байгууллагын хүний эрхийн магадлан шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлэх талаар төрөөс олон арга хэмжээг авахаар харагдаж буй юм.

Олон улсын туршлагаас харахад НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх буюу хүний эрхийн магадлан шинжилгээг тогтмол хийдэг байх нь бизнесийн үйл ажиллагаанаас хамааралтай нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөө бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх замаар өөрийн үйл ажиллагааны нөлөөлөл, эрсдлийг хянах хамгийн үр дүнтэй арга хэмжээ болдог байна.

Иймд өндөр эрсдэлтэй салбар болох уул уурхай, зам, тээвэр, дэд бүтэц, хүнд үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд нь Менежментийн төлөвлөгөөгөө илүү бодитой, үр дүнтэй хийж, хэрэгжилтийг нь хянахын тулд хүний эрхийн магадлан шинжилгээг тогтмол хийх шаардлагатай.



Хэрэв та хүний эрхийн магадлан шинжилгээ болон НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын талаар илүү ойлголт, мэдээлэлтэй болохыг хүсвэл бидэнтэй холбогдоно уу.

Та дараах линкээр орж шинэ БОНУЖ-тай танилцана уу: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758850092381>



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд дурдсан тухайн асуудал бүрээр олон талын цогц дүн шинжилгээг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН -ийг илэрхийлнэ.